УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБА
ИЛТГЭХ ХУУДАС

Хэрэгжилт удааширсан ажлуудад мониторинг хийсэн тухай

2015 оны 10 дугаар сарын 26 Улаанбаатар хот

Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2013-2016 оны үйл ажиллагааны 1.4.3 дахь заалтад тусгагдсан "Төв цэвэрлэх байгууламжийн технологийн шинэчлэл хийж өргөтгөн, хүчин чадлыг нь нэмэгдүүлэхийн зэрэгцээ хотын алслагдсан хэсэг, дагуул хот, тосгодод биё даасан орчин үеийн шинэ технологийн цэвэрлэх байгууламжуудыг байгуулах", 2.2.3 дахь заалтад тусгагдсан "Эрдэнэ толгой, УС-15, Амгалан дулааны станц орчмын үерийн хамгаалалтын байгууламжийг барих", 4.4.4 дахь заалтад тусгагдсан "Чингэлтэй болон Баянгол дүүргийн нутаг дэвсгэр дэх Баруун уулын үерийн хамгаалалтын засвар шинэчлэлтийн барилга угсралтын 2 дугаар ээлжийн ажил", "Сонгино хайрхан дүүргийн 1, 2, 3, 20 дугаар хорооны нутаг дэвсгэр дэх Нарангийн үерийн хамгаалалтын барилга байгууламжийн барилга угсралтын ажлын 2 дугаар ээлжийг барих" ажлуудад мониторинг хийлээ.

1. *Төв цэвэрлэх байгууламжийн өргөтгөл, шинэчлэл, шинээр барих ажлын ТЭЗҮ, зураг төсөл боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлын талаар:*

"Төслийн хэрэгжилтийг хангах тухай" Нийслэлийн Засаг даргын 2015 оны 06 дугаар сарын 16-ны өдрийн А/507 дугаар захирамжаар Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/745 дугаар захирамжаар байгуулагдсан үнэлгээний хорооны шийдвэрийг хүчинтэйд тооцон, төндөрт шалгарсан компанитай гэрээ байгуулан гүйцэтгүүлэхийг НХОГ, УСУГ-т үүрэг болгосон байна.

"Туул усан сан цогцолбор" байгуулах төслийн ТЭЗҮ боловсруулах зөвлөх үйлчилгээний ажлыг Францын "Артеллиа Вилл энд Транспорт" ХХК гүйцэтгэхээр шалгарч, Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газартай 2015 оны 07 дугаар сарын 29-ний өдөр НХААГ-14/0221 тоот гэрээ байгуулсан.

Одоогийн байдлаар байгаль орчны өрөнхий үнэлгээ, геологи, геодези, топо зураглал, цэвэрлэх байгууламжуудын процессийн зураг, өрөнхий төлөвлөгөө, үндсэн болон туслах барилгуудын зургийг хийж гүйцэтгэсэн. Техник эдийн засгийн үндэслэл батлагдах хурал зохион байгуулагдах гэж байна. Ажлын явц 90 %-тай .

2. *Эрдэнэ толгой, УС-15, Амгалан дулааны станц орчмын үерийн хамгаалалтын байгууламжийг барих ажлын талаар*

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/95 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас төндер зарлан, ажлын гүйцэтгэгчээр "Ардааган" ХХК шалгарсан.

Нийт 3600 метр сувагчлалын ажил хийгдэхээс энэ ондоо үерийн байгууламжийн суваг-1-ийн угсралтын ажил 430 м, үерийн байгууламжийн суваг-2-ын угсралтын ажил 620 м, нийт 1050 м сувагчлал угсралтын ажил хийгдсэн байна.

Амгалан дулааны станцын ажилтай уялдуулан трасс өөрчлөх болон иргэдийн өмчлөлийн газар чөлөөлөлтийн ажил удааширснаас ажлын гүйцэтгэл 40%-тай байна. Цаашид ажил он дамжин хийгдэхээр болжээ.

3. *Баруун уулын үерийн хамгаалалтын барилга угсралтын ажлын талаар*

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/95 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас төндер зарласан.

Баруун уулын үерийн хамгаалалтын суваг нь 1970-1983 онд баригдсан бөгөөд хотын төвийн хэсгийн гадаргын усыг зайлуулах зориулалт бүхий 11.0 км урт инженерийн бэлтгэл арга хэмжээний байгууламж юм.

2014 оноос тус байгууламжийн засвар шинэчлэлтийн ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж "Шимт газар" ХХК, "Усны барилга" ХХК барилга угсралтын ажлыг гүйцэтгэж байна.

"Шимт газар" ХХК нь 1003 м засвар шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэн, ашиглалтанд хүлээлгэн өгөх бэлтгэл ажлыг хийж байна. Тус компаний хувьд ажлын гүйцэтгэл 100%-тай байна.

"Усны барилга" ХХК нь 430.7 м засвар шинэчлэлтийн ажил хийж гүйцэтгэхээс энэ ондоо 320 м байгууламжийн ажлыг хийж гүйцэтгэн 110.7 м байгууламжийн ажлыг 2016 ондоо хийж гүйцэтгэхээр болсон. Ажлын гүйцэтгэл 80%.

Үлдсэн 970 метр сувагчлалын ажил нь цаашид үе шаттайгаар он дамжин хийгдэхээр төлөвлөгдсөн байна.

4. Нарангийн үерийн хамгаалалтын барилга угсралтын ажлын талаар

Нийслэлийн Засаг даргын 2015 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн "Үнэлгээний хороо байгуулах тухай" А/95 дугаар захирамжийн дагуу Нийслэлийн Худалдан авах ажиллагааны газраас төндөр зарласан боловч гүйцэтгэгч компани өнөөг хүртэл шалгараагүй байна.

Дүгнэлт:

1. Дээрх ажлуудын биелэлтэнд Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар шууд хяналт тавин ажиллаж байгаа тул ажлын биелэлтийг НХОГ-аас шууд гаргуулах талаар НЗДТГ-ын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст албан тоот явуулж, хэлтсийн биелэлтээс хасуулах арга хэмжээ авах шаардлагатай байна.
   ЗАА-ны биелэлтээс хасах боломжгүй тохиолдолд журмын дагуу гүйцэтгэлийн хувийг дээшлүүлэх талаар ярилцаж шийдвэрлэх хэрэгтэй.
2. Нарангийн үерийн хамгаалалтын барилга угсралтын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажил өнөөг хүртэл хийгдээгүй тул НХААГ-аар гүйцэтгэлийг гаргуулж, хэлтсийн биелэлтээс хасуулах арга хэмжээг авах хэрэгтэй .

Дээрх асуудлыг шийдвэрлэж "Инженерийн байгууламжийн хэлтсийн 2015 оны эхний хагас жилийн үйл ажиллагааны тайлан"-гийн хяналт-шинжилгээний зөвлөмжийн дагуу хариуг 11 дүгээр сарын 20-ны дотор эргэж мэдэгдэх шаардлага тавьж байна.

ТАНИЛЦСАН:
ҮАМХ-ИЙН ДАРГА Н.БАТСҮХ

БОЛОВСРУУЛСАН:
ҮАМХ-ИЙН МЭРГЭЖИЛТЭН Б.ЭРДЭНЭБАТ